

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын хорин найм дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/83/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Ц.Одгэрэл
Утас: 70357955 Цахим хаяг: odgerelts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.08.19 № 02

танай _____-ны № _____-т

ХОРИН НАЙМ ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ М.БАТЦЭЦЭГ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын хорин найм дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын хорин найм дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус цэцэрлэг нь 63,293.5 мянган төгрөгийн төсөвтэй хүүхдийн хоолны материал худалдан авах цахим тендерийг 6 удаа харьцуулалтын аргаар зохион байгуулсан.

Аудитын гол асуудал

Боловсролын байгууллага гүйцэтгэлд суурилсан төсвөөр санхүүжих болсноор сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрөөс хэрэгжүүлэх арга хэмжээ 8 болж, зардлын зүйл анги багасаж, ихэнх зардал бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулахаар болсон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээнд Улсын төсвөөс 735,712.8 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 49,109.1 мянган төгрөгийн санхүүжилт, төсөл хэрэгжүүлэх 25,155.0 мянган төгрөгийн орлого олсноос, 686,585.9 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, 5,689.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, байгууллагын төсвийн харилцах дансанд 143,114.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаж, төсвийн гүйцэтгэл 80.1 хувьтай байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 251.0 сая төгрөгөөр 8 удаа нэмэгдүүлж тодотгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд "Монтесори стим" төслийг хэрэгжүүлэхээр Засаг даргын нөөц сангаас 25,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч тус цэцэрлэгийн 4 ангийг тохижуулсан байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй Төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	99,629,627.36	225,198,994.05
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	50,413,557.60	143,114,662.09
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	50,413,557.60	143,114,662.09
3121	Төгрөг	50,413,557.60	143,114,662.09
31211	Төрийн сангийн харилцах	50,413,557.60	143,114,662.09
33	АВЛАГА	510,649.76	8,760.96
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	45,649.76	8,760.96
335	Бусад авлага	465,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	465,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	48,705,420.00	82,075,571.00
351	Түүхий эд материал	42,895,045.00	64,769,771.00
35110	Тусгай зориулалттай материал	42,895,045.00	64,769,771.00
354	Хангамжийн материал	5,810,375.00	17,305,800.00
35420	Аж ахуйн материал	4,278,000.00	3,151,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,532,375.00	14,013,800.00
35470	Бусад хангамжийн материал	-	141,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,341,829,059.56	2,291,011,112.09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,341,829,059.56	2,291,011,112.09
392	Биет хөрөнгө	2,113,296,304.06	2,062,953,332.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,851,942,000.00	1,851,942,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(42,552,114.39)	(84,808,707.39)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	64,200,958.00	71,772,958.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,811,879.25)	(20,740,617.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,859,895.85	28,839,895.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,922,233.68)	(4,032,723.37)
39209	Зам, гүүрийн байгууламж	239,978,757.00	239,978,757.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(10,399,079.47)	(19,998,229.75)
393	Биет бус хөрөнгө	228,532,755.50	228,057,779.30
39303	Бусад биет бус хөрөнгө	228,928,569.00	228,928,569.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(395,813.50)	(870,789.70)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,441,458,686.92	2,516,210,106.14
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,441,458,686.92	2,516,210,106.14
51	Засгийн газрын хувь оролцоо	2,441,458,686.92	2,516,210,106.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	200,430,000.00	200,430,000.00
51101	Өмч: - төрийн	200,430,000.00	200,430,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,241,028,686.92	2,315,780,106.14
51210	Өмнөх үеийн үр дүн	2,241,028,686.92	2,241,028,686.92
51220	Тайлант үеийн үр дүн	-	74,751,419.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,441,458,686.92	2,516,210,106.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,940,785,018.00	912,886,350.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,853,568,118.00	128,064,450.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,355,550,418.00	128,064,450.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	25,155,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		25,155,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан -Үндсэн хөрөнгө	2,300,345,636.00	11,752,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан -Бараа материал	55,204,782.00	91,157,450.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	498,017,700.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	498,017,700.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	87,216,900.00	784,821,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	735,712,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	735,712,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	87,216,900.00	49,109,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	87,216,900.00	49,109,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	601,685,602.97	838,134,930.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	601,685,602.97	838,134,930.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	601,386,448.23	832,445,119.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	379,678,108.48	506,833,398.30
210101	Үндсэн цалин	325,337,974.62	374,173,955.84
210102	Нэмэгдэл	49,774,976.12	117,468,345.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	323,200.00	1,341,000.00
210104	Урамшуулал	4,241,957.74	13,850,097.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,946,913.87	63,570,982.01
210201	Тэтгэврийн даатгал	31,875,489.25	43,391,196.86
210202	Тэтгэмжийн даатгал	3,807,915.93	5,044,944.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,043,132.81	4,035,956.05
210204	Ажилгүйдлийн даатгал	928,553.79	1,008,989.56
210205	Эрүүл мэндийн даатгал	7,291,822.09	10,089,894.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,250,244.38	89,045,924.28
210301	Гэрэл, цахилгаан	10,308,419.38	14,745,749.28
210302	Түлш, халаалт	18,717,625.00	55,318,575.00
210303	Цэвэр, бохир ус	14,224,200.00	18,981,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,687,174.00	24,011,896.00
210401	Бичиг хэрэг	11,905,574.00	14,820,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,781,600.00	9,191,796.00
2105	Нормативт зардал	44,098,806.00	55,586,230.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	54,810.00	-
210502	Хоол, хүнс	44,043,996.00	54,986,230.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,028,900.00	9,691,939.00
210604	Урсгал засвар	1,028,900.00	9,691,939.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	780,000.00	3,439,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,164,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	780,000.00	1,275,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,916,301.50	80,265,749.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,253,490.17	8,580,842.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,786,963.00	4,314,960.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,875,848.33	67,369,947.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	299,154.74	5,689,811.72
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	299,154.74	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	299,154.74	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,689,811.72
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,689,811.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,339,099,415.03	74,751,419.22
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	97,945,283.68	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	97,945,283.68	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(97,945,283.68)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,241,154,131.35	74,751,419.22

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	585,234,600.00	809,976,900.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	498,017,700.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	498,017,700.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	87,216,900.00	784,821,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	735,712,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	735,712,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	87,216,900.00	49,109,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	87,216,900.00	49,109,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	534,821,042.40	712,475,795.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	534,821,042.40	712,475,795.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	534,521,887.66	706,785,983.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	379,723,758.24	506,796,509.50
210101	Үндсэн цалин	325,369,605.72	374,137,067.04
210102	Нэмэгдэл	49,774,976.12	117,468,345.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	323,200.00	1,341,000.00
210104	Урамшуулал	4,255,976.40	13,850,097.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,946,913.87	63,570,982.01
210201	Тэтгэврийн даатгал	31,875,489.25	43,391,196.86
210202	Тэтгэмжийн даатгал	3,807,915.93	5,044,944.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,043,132.81	4,035,956.05
210204	Ажилгүйдлийн даатгал	747,306.63	1,008,989.56

210205	Эрүүл мэндийн даатгал	7,473,069.25	10,089,894.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,782,619.38	33,727,349.28
210301	Гэрэл, цахилгаан	10,308,419.38	14,745,749.28
210302	Түлш, халаалт	20,250,000.00	-
210303	Цэвэр, бохир ус	14,224,200.00	18,981,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,071,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,071,000.00	-
2105	Нормативт зардал	44,043,996.00	54,679,980.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	44,043,996.00	54,679,980.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,130,900.00	9,691,939.00
210604	Урсгал засвар	1,130,900.00	9,691,939.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,245,000.00	2,974,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,164,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,245,000.00	810,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,577,700.17	35,345,224.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,577,700.17	31,851,832.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000,000.00	3,493,392.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	299,154.74	5,689,811.72
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	299,154.74	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	299,154.74	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,689,811.72
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,689,811.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	50,413,557.60	97,501,104.49
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	4,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	4,800,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	4,800,000.00
223001	Бусад хөрөнгө	-	4,800,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(4,800,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	50,413,557.60	92,701,104.49
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	50,413,557.60
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	50,413,557.60	143,114,662.09

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	200,430,000.00	2,241,028,686.92	2,441,458,686.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	200,430,000.00	2,241,028,686.92	2,441,458,686.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-

D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	74,751,419.22	74,751,419.22
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	200,430,000.00	2,315,780,106.14	2,516,210,106.14

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл					
2	71801 - СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ					
2	80112 - НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ					
2	1230	УТ, ОНТ хоорондын шилжүүлэг	57,979,900.00	49,109,100.00	8,870,800.00	84.7
3	123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	57,979,900.00	49,109,100.00	8,870,800.00	84.7
4	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,907,100.00	33,727,349.28	20,179,750.72	62.57
5	210301	Гэрэл, цахилгаан	24,282,300.00	14,745,749.28	9,536,550.72	60.73
6	210303	Цэвэр, бохир ус	29,624,800.00	18,981,600.00	10,643,200.00	64.07
7	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	9,691,939.00	308,061.00	96.92
8	210604	Урсгал засвар	10,000,000.00	9,691,939.00	308,061.00	96.92
9	261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		5,689,811.72	-5,689,811.72	
10	81605 - ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ					
10	1230	УТ, ОНТ хоорондын шилжүүлэг	1,702,200.00		1,702,200.00	
11	123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,702,200.00		1,702,200.00	
12	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,702,200.00	1,702,200.00		100
13	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,702,200.00	1,702,200.00		100
14	310001	Улсын төсвөөс санхүүжих		1,702,200.00	-1,702,200.00	
15	81807 - ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН ХООЛ					
15	1230	УТ, ОНТ хоорондын шилжүүлэг	63,293,500.00		63,293,500.00	
16	123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	63,293,500.00		63,293,500.00	
17	2105	Нормативт зардал	63,293,500.00	54,679,980.00	8,613,520.00	86.39
18	210502	Хоол, хүнс	63,293,500.00	54,679,980.00	8,613,520.00	86.39
19	310001	Улсын төсвөөс санхүүжих		59,491,400.00	59,491,400.00	
20	81816 - ЗӨВ МОНГОЛ ХҮҮХЭД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР					
20	1230	УТ, ОНТ хоорондын шилжүүлэг	3,503,700.00		3,503,700.00	
21	123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	3,503,700.00		3,503,700.00	
22	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,503,700.00	3,500,000.00	3,700.00	99.89
23	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,503,700.00	3,500,000.00	3,700.00	99.89
24	310001	Улсын төсвөөс санхүүжих		3,503,700.00	-3,503,700.00	
25	81823 - БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН БАГШ АЖИЛЧДЫН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ					
25	1230	УТ, ОНТ хоорондын шилжүүлэг	1,702,200.00		1,702,200.00	
26	123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,702,200.00		1,702,200.00	
27	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,702,200.00	1,400,300.00	301,900.00	82.26

28	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,702,200.00	1,400,300.00	301,900.00	82.26
29	310001	Улсын төсвөөс санхүүжих		1,702,200.00	-1,702,200.00	
30	81834 - БОЛОВСРОЛЫН СТАНДАРТ, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ					
30	1230	УТ, ОНТ хоорондын шилжүүлэг	451,312,400.00		451,312,400.00	
31	123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	451,312,400.00		451,312,400.00	
32	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	416,918,200.00	336,492,460.38	80,425,739.62	80.71
33	210101	Үндсэн цалин	296,500,700.00	267,329,712.36	29,170,987.64	90.16
34	210102	Нэмэгдэл	117,929,500.00	64,220,195.07	53,709,304.93	54.46
35	210103	Унаа хоолны хөнгөлөлт		754,000.00	-754,000.00	
36	210104	Урамшуулал	2,488,000.00	4,188,552.95	-1,700,552.95	168.35
37	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,326,900.00	41,973,633.17	10,353,266.83	80.21
38	210201	Тэтгэврийн даатгал	35,650,300.00	28,616,998.37	7,033,301.63	80.27
39	210202	Тэтгэмжийн даатгал	4,169,100.00	3,339,158.51	829,941.49	80.09
40	210203	ҮОМШӨ-ний даатгал	3,335,300.00	2,671,325.62	663,974.38	80.09
41	210204	Ажилгүйдлийн даатгал	833,900.00	667,831.88	166,068.12	80.09
42	210205	Эрүүл мэндийн даатгал	8,338,300.00	6,678,318.79	1,659,981.21	80.09
43	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,134,600.00	810,000.00	324,600.00	71.39
44	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,134,600.00	810,000.00	324,600.00	71.39
45	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,692,300.00	10,551,724.00	140,576.00	98.69
46	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,287,900.00	7,147,332.00	140,568.00	98.07
47	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,404,400.00	3,404,392.00	8	100
48	310001	Улсын төсвөөс санхүүжих		451,312,400.00	-451,312,400.00	
49	81835 - СУРГАЛТЫН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ					
49	1230	УТ, ОНТ хоорондын шилжүүлэг	218,000,900.00		218,000,900.00	
50	123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	218,000,900.00		218,000,900.00	
51	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	199,614,500.00	170,304,049.12	29,310,450.88	85.32
52	210101	Үндсэн цалин	108,097,700.00	106,807,354.68	1,290,345.32	98.81
53	210102	Нэмэгдэл	77,142,200.00	53,248,150.14	23,894,049.86	69.03
54	210103	Унаа хоолны хөнгөлөлт		587,000.00	-587,000.00	
55	210104	Урамшуулал	14,374,600.00	9,661,544.30	4,713,055.70	67.21
56	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,951,400.00	21,597,348.84	3,354,051.16	86.56
57	210201	Тэтгэврийн даатгал	16,967,200.00	14,774,198.49	2,193,001.51	87.08
58	210202	Тэтгэмжийн даатгал	1,996,400.00	1,705,786.13	290,613.87	85.44
59	210203	ҮОМШӨ-ний даатгал	1,596,800.00	1,364,630.43	232,169.57	85.46
60	210204	Ажилгүйдлийн даатгал	399,000.00	341,157.68	57,842.32	85.5
61	210205	Эрүүл мэндийн даатгал	3,992,000.00	3,411,576.11	580,423.89	85.46

62	310001	Улсын төсвөөс санхүүжих		218,000,900.0 0	218,000,900.0 0	- 0
63	81844	ГҮНЗГИЙРҮҮЛСЭН БОЛОН ТӨРӨЛЖСӨН СУРГАЛТЫН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ				
63	1200	Татварын бус орлого	155,000.00	155,000.00		100
64	120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	155,000.00	155,000.00		100
65	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	155,000.00	155,000.00		100
66	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	155,000.00	155,000.00		100
67	83602	ЗГ БОЛОН ЗД-ЫН НӨӨЦ ХӨРӨНГӨӨС ХУВААРИЛСАН				
67	1200	Татварын бус орлого		25,000,000.00	25,000,000.00	-
68	120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/		25,000,000.00	25,000,000.00	-
69	1230	УТ, ОНТ хоорондын шилжүүлэг	25,000,000.00		25,000,000.00	
70	123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	25,000,000.00		25,000,000.00	
71	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,800,000.00	4,800,000.00		100
72	210602	Тавилга	4,800,000.00	4,800,000.00		100
73	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,164,000.00	2,164,000.00		100
74	210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,164,000.00	2,164,000.00		100
75	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,036,000.00	18,036,000.00		100
76	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,036,000.00	18,036,000.00		100
77	БУСАД ЭХ ҮҮСВЭР					
78		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		50,413,557.60	50,413,557.60	-
79		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		143,114,662.0 9	143,114,662.0 9	-
81	БАЙГУУЛЛАГЫН ТОО		1	1		100
82	АЖИЛЛАГСАДЫН ТОО		36	36		100
83	Удирдах ажилтан		1	1		100
84	Гүйцэтгэх ажилтан		22	22		100
85	Үйлчлэх ажилтан		14	14		100
86	Төрийн өмчит СӨБ байгууллага		1	1		100
87	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ		36	36		100
88	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)		19	19		100
89	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)		1	1		100
90	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)		16	16		100

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 25,327.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 25,327.8 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Залруулсан алдаа:

- Төслийн санхүүжилт 25,000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн орлогоор тайлагнасан.
- Тайлант онд хандиваар болон худалдан авсан 327.8 мянган төгрөгийн ном буюу тусгай зориулалтын материалыг үндсэн хөрөнгөөр тайлагнасан.

Аудитаар нийт 8,423.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 862.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 6,770.1 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 791.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын ур чадварын аварга багш, шилдэг ажилтнаар 2 албан хаагчийг шалгаруулж цалингийн зардлаас 550.0 мянган төгрөгөөр шагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. Багшийн цахим хэрэглээний 240.0 мянган төгрөгийн дата багцыг журамд заагаагүй 3 албан хаагчид олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.1-т "гар утасны зардал", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх хуваарилах заавар"-ын 2.4-д "дата багцыг сонгосон нөхцөлд цахим хэрэглээний нийт зардлыг нийт үндсэн багш (бүлгийн болон хөгжим, биеийн тамирын багшийн нийт тоо) тоонд хувааж тухайн хугацаанд ашиглах цахим хэрэглээний зардлын нэгжийг тооцно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3. Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар хяналтын тооллого хийхэд 72.7 мянган төгрөгийн хүнсний материал дутагдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

1. Албан хаагчдад үр дүн, ур чадварын нэмэгдлийг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлэлгүй 6,770.1 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.5-д "энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Худалдан авч орлогоор бүртгэсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үнийн дүнг цахим төлбөрийн баримтад нийт дүнгээр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн бүртгэж, тайлагнах.

2. Цалин хөлсний тооцоололтой холбоотой

Илрүүлэлт:

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайланг 791.0 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цалин хөлстэй холбоотой тайлан, мэдээг үнэн зөв тайлагнаж байх.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхон аймгийн Баян-Өндөр сумын хорин найм дугаар цэцэрлэг	2	25,327.8			2	25,327.8	2	25,327.8				
Дүн	2	25,327.8			2	25,327.8	2	25,327.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Баян-Өндөр сумын хорин найм дугаар цэцэрлэг	6	8,423.8	3	862.7	1	6,770.1	2	791.0				
Дүн	6	8,423.8	3	862.7	1	6,770.1	2	791.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Орхон аймгийн Баян-Өндөр сумын хорин найм дугаар цэцэрлэг	1	2,551.8							1	2,551.8
Дүн	1	2,551.8							1	2,551.8
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Орхон аймгийн Баян-Өндөр сумын хорин найм дугаар цэцэрлэг										
Дүн										
Нийт дүн	1	2,551.8							1	2,551.8

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			